



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 49

Баруун-Урт

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 "к" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам"-ийг 1 дүгээр хавсралтаар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах контрактын загварыг 2 дугаар, орон нутгийн өмчит компанийн захиралтай байгуулах контрактын загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам"-ийг мөрдөж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар, орон нутгийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг дагаж мөрдөж ажиллахыг орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөсүгэй.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбаатар/-т даалгасугай.

ДАРГА

Б.МӨНХБАТ

01000100

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчийн компани захиралтай контракт байгуулах, дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, дүгнэх, урамшуулал олгох болон холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2 “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, Орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захиралтай контракт байгуулах, дүгнэхэд дагаж мөрдөнө.

1.3 Энэхүү журамд цаашид орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийг “хуулийн этгээд”, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал, орон нутгийн өмчит компанийн ерөнхий захирал, гүйцэтгэх захирлыг “захирал” гэнэ.

Хоёр. Контракт байгуулах

2.1 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн ерөнхий захирал, гүйцэтгэх захиралтай контрактыг 1 хүртэл жилийн хугацаагаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлуулна.

2.2 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай Аймгийн Засаг дарга, түүнийг төлөөлж Орон нутгийн өмчийн газрын дарга контракт байгуулна.

2.3 Орон нутгийн өмчит компанийн ерөнхий захирал, гүйцэтгэх захиралтай тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга контракт байгуулна.

2.4 Хуулийн этгээдийн захирлын контрактад тухайн оны батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон хөрөнгө хүлээлгэн өгсөн акт нь контрактын салшгүй хэсэг болно.

2.5 Контракт байгуулсан этгээд нь контрактад дугаар олгох бөгөөд контрактыг зохих журам, зааврын дагуу тамга, тэмдгээр баталгаажуулна.

Гурав. Контрактыг дүгнэх

3.1 Хуулийн этгээдийн захиралтай байгуулсан контрактыг жилийн эцсийн тайлан хэлэлцэх үед болон Контрактын хугацаа дуусгавар болох үед Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дүгнэнэ.

3.2 Хуулийн этгээдийн захирал нь дараах материалыг бүрдүүлж, Орон нутгийн өмчийн газарт дараа оны 03 дугаар сарын 20- ны өдрийн дотор хүргүүлнэ:

3.2.1 Контрактын биелэлт;

1.4	Цэвэр ашиг/ алдагдал	10,0	10,0
1.5	Борлуултын орлогын 1төг-т ногдох зардал	5,0	5,0
1.6	Нийт авлага	10,0	5,0
1.7	Нийт өглөг	10,0	5,0
1.8	Хөрөнгө оруулалт, их засвар, төлөвлөгөөний биелэлт	5,0	5,0
1.9	Төрийн өмчийн ногдол ашгийн гүйцэтгэл улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй байх	5,0	5,0
2.0	Тайлангийн үр дүн		
2.1	Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт	6,0	6,0
2.2	Захирлын ажлын тайлан	2,0	2,0
2.3	АИТХ болон ТУЗ-ийн шийдвэрийн биелэлт	5,0	8,0
2.4	Худалдан авах ажиллагааны тухай хууль, Шилэн дансны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн биелэлт	5,0	5,0
2.5	Хэрэглэгчийн санал асуулгын дүн	3,0	4,0
2.6	Ажиллагсадын санал асуулгын дүн	4,0	5,0
3.0	Харьяалах салбарын яам, төрийн захиргааны холбогдох байгууллагын үнэлгээ /шийдвэрийн хэрэгжилт/	15,0	15,0
	Нийт оноо	100,0	100,0

3.8 Энэхүү журмын 3.6-д заасан шалгуур үзүүлэлтийн нийт дүнгээр 86-100 оноо авсан бол захирлын контрактын биелэлтийг “Сайн”, 71-85 оноо авсан бол “хангалттай”, 70 болон түүнээс доош оноо авсан бол “Хангалтгүй” гэж тус тус дүгнэнэ.

3.9 Орон нутгийн өмчит компанийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн болон контрактын биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан гаргах бөгөөд Орон нутгийн өмчийн газар хяналт тавина.

3.10 Захирлын ажлыг дүгнэхэд хуулийн этгээдийн ажилтнууд болон хэрэглэгч үйлчлүүлэгчдээс санал асуулга авна. Санал асуулгыг шаардлагатай нөхцөлд тухайн жилийн явцад 2-оос доошгүй удаа авсан байна.

3.11 Орон нутгийн өмчийн газар болон тухайн хуулийн этгээдийн хүний нөөц, дотоод ажил хариуцсан ажилтан нь энэхүү журмын 3.11-д заасан санал асуулгыг авна.

Дөрөв. Урамшуулал олгох

4.1 Контрактын биелэлт нь “Сайн” гэж дүгнэгдсэн, цэвэр ашгийн төлөвлөгөөг биелүүлсэн, төрийн өмчийн ногдол ашгийг бүрэн төвлөрүүлсэн, улс, орон нутгийн төсөвт өр төлбөргүй захиралд урамшуулал олгоно.

4.2 Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдийн захиралд урамшуулал олгох асуудлыг Орон нутгийн өмчийн газар нэгтгэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралаар танилцуулан шийдвэрлүүлнэ.

4.3 Урамшууллыг валютын ханш, үнэ тарифын өөрчлөлтөөс олсон ашгийг хассан цэвэр ашгаас тооцох бөгөөд урамшууллын хувийг дараах хүснэгтийн дагуу тогтооно.

3.2.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл;

3.2.3 Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;

3.2.4 Аудитын тайлан, зөвлөмж;

3.2.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн санал дүгнэлт, шийдвэр;

3.2.6 Аудитын компанийн сүүлийн 2 жилд өгсөн зөвлөмжийн биелэлт;

3.2.7 Захирлын ажлын тайлан;

3.3 Энэхүү журмын 3.2-т заасан материалыг судалж, санал дүгнэлт боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.

3.4 Ажлын хэсэгт Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс болон холбогдох төрийн захиргааны байгууллагын мэргэжилтнийг оруулна.

3.5 Ажлын хэсэг контрактыг эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны сүүлчийн 2 жилийн үзүүлэлт болон хасвралтад заасан үзүүлэлтээр тус тус дүгнэнэ.

3.6 Контрактын биелэлтийг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо
1	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл	60
	А. Эрчим хүчний компани Б. Бусад хуулийн этгээд	55
2	Тайлангийн үр дүн, хууль тогтоомжийн биелэлт	25
	А. Эрчим хүчний компани Б. Бусад хуулийн этгээд	30
3	Харьяалах салбарын яам, төрийн захиргааны байгууллагын үнэлгээ /шийдвэрийн хэрэгжилт/	15
4	Нийт оноо	100

3.7 Контрактын биелэлтийг доорхи маягтын дагуу тооцно.

№	Дүгнэх үзүүлэлт	Үнэлгээнд тавих оноо	
		Эрчим хүчний	Бусад
1	Эдийн засгийн үзүүлэлт		
1.1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /гол нэр төрлөөр/	5,0	5,0
	а		
	б		
1.2	Нийт орлого	5,0	10,0
1.3	Нийт зардал	5,0	5,0

№	Цэвэр ашгийн дүн /төгрөг/	Урамшууллын хувь
1	1,000,000 хүртэл	10
2	1,000,001-10,000,000 сая хүртэл	8
3	10,000,001-30,000,000 сая хүртэл	6
9	30,000,001-50,000,000 сая хүртэл	4
	50,000,001 сая дээш	2

4.4 Хуулийн этгээд нь үндсэн үйл ажиллагаанаас ашигтай, валютын ханшийн зөрүүнээс алдагдалтай ажилласан тохиолдолд захиралд урамшуулал олгож болно. Энэ тохиолдолд урамшууллын дээд хэмжээ дээрх хүснэгтийн дагуу тогтоосон урамшууллын хэмжээний 50 хувиас хэтрэхгүй байна.

4.5 Захиралд ажилласан хугацаанд нь ногдох хэмжээгээр урамшуулал олгоно.

4.6 Захиралд дараах нөхцөлд урамшуулал олгохгүй:

4.6.1 Өмч хөрөнгө үрэгдүүлсэн, шамшигдуулсан нь нотлогдсон;

4.6.2 Осол аваарын улмаас хүний амь нас эрсэдсэн, хүнд гэмтэл учирсан, их хэмжээний хохирол гарсан;

4.6.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн нь нотлогдсон;

4.6.4 Тухайн жилд хуанлийн 90 болон түүнээс доош хоног ажилласан;

4.7 Үйлдвэрлэлийн технологийн горим, тогтвортой үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай төлөвлөгөөт ажил, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хэмнэж олсон ашгийн нөлөөллийг цэвэр ашгаас хасаж тооцно.

4.8 Захиралд олгох урамшууллыг Орон нутгийн өмчийн газар, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн хуулийн этгээдийн санхүүгийн зохих эх үүсвэрээс гаргана.

Тав. Бусад

5.1 Контракт нь "хангалтгүй" гэж дүгнэгдсэн захиралд холбогдох хууль тогтоомж, контрактад заасан хариуцлага тооцох саналыг Орон нутгийн өмчийн газар боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн газрын хуралаар танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.2 Энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.3 Хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцлийг буруу гаргасан нь тогтоогдсон нөхцөлд захиралд олгосон урамшууллыг буцаан төлүүлнэ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн
49 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

“.....” ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ КОНТРАКТЫН ЗАГВАР

20... оны дугаар сарын
сарын-ны өдөр

Дугаар

Баруун-Урт
хот

Энэхүү контрактыг нэг талаас Аймгийн Засаг дарга, түүнийг төлөөлж Орон нутгийн өмчийн газрын дарга/цаашид “ажил олгогч/ гэх, нөгөө талаас “ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал/цаашид “захирал”/ гэх, нар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 22, 25 дугаар зүйл, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 20... оны дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү контрактын зорилго нь “.....” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, контрактаар хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, талуудын харилцан эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.

1.2 Энэхүү контракт нь 20.. оны ...дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн 20 ...оныдугаар сарын ... –ны өдрийг дуустал 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

1.3 “.....” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 20 ... оны дугаар улирлын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан.....
(.....)
төгрөгийн үндсэн
(.....)
төгрөгийн эргэлтийн, нийт
(.....)
төгрөгийн хөрөнгийг контракт байгуулсан өдөр хавсралтаар хүлээлгэн өгөв.

Ажил олгогчийг төлөөлж:
.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

Захирал
.....

1.4 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс “.....” орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын 20... оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь энэхүү контрактын салшгүй хэсэг бөгөөд захирлын хийх ажлын хүрэх үр дүн болно.

1.5 Контрактын биелэлтийг жилийн эцсийн тайлан, тайлан хэлэлцэх болон контрактын хугацаа дуусгавар болох үед “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу дүгнэнэ.

1.6 Контрактыг сунгахаар шийдвэрлэсэн нөхцөлд аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан үндсэн болон эргэлтийн хөрөнгийг сүүлийн байдлаар хүлээлгэн өгнө.

Хоёр. Ажил олгогчийн эдлэх эрх, хүлээх үүрэг

2.1 Захиралд цалин хөлс, ажлын үр дүнд нь тохирсон шагнал, урамшууллыг энэхүү контрактад заасан нөхцөлийн дагуу олгох үүрэгтэй.

2.2 Үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.

2.3 Үйлдвэрийн газрын цэвэр ашгаас төрд төвлөрүүлэх болон орлогын өсөлт, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, эргэлтийн хөрөнгийн эх үүсвэр зэргийг харгалзан батлах эрхтэй.

2.4 Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тоо, цалингийн сангийн хэмжээг батлах эрхтэй.

2.5 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны онцлог, ажлын шаардлагыг харгалзан удирдлагын зөвлөлийг томилон ажиллуулах үүрэгтэй.

2.6 Захирал 30-аас дээш хоногийн хугацаагаар эзгүй байх /контрактаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүй/ тохиолдолд захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилж, эрх, үүргийг нь тогтоох үүрэгтэй.

2.7 Захирлын контрактаар хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхтэй холбогдуулж тавьсан саналд тухай бүр хариу өгөх, холбогдох мэдээллээр хангах үүрэгтэй.

2.8 Захирлын ажлын тайлан, контрактын биелэлтийг зохих журмын дагуу дүгнэх эрхтэй.

2.9 Ажлын явц, гүйцэтгэлтэй тухай бүр танилцаж санал, зөвлөгөө өгөх, шаардлага тавих эрхтэй.

Ажил олгогчийг төлөөлж:
.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

Захирал
.....

2.10 Захирал контрактаар хүлээсэн үүргээ бүрэн, бодитой, зохих ёсоор гүйцэтгээгүй бол хууль тогтоомж, энэхүү контрактад заасны дагуу арга хэмжээг авах сахилгын шийтгэл ногдуулах эрхтэй.

2.11 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг

Гурав. Захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг

3.1 Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомж, дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах эрхтэй.

3.2 Үйлдвэрийн менежментийг боловсронгуй болгох, техник технологийг шинэчлэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үзүүлэлт бүрээр биелүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанарыг өндөр түвшинд хүргэх, өртөг, зардлыг хямдруулах, өр авлагыг бууруулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэж ажиллах үүрэгтэй.

3.3 Үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр гадаад, дотоодод төлөөлөх, итгэмжлэл олгох үүрэгтэй.

3.4 Өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд бусад хуулийн этгээд, иргэдтэй гэрээ, хэлцэл байгуулах эрхтэй.

3.5 Хүний нөөцийн бодлого боловсруулж батлах.

3.6 Ажилтнуудын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж батлах.

3.7 Захирал дараах асуудлыг зөвхөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэргүүлэгчдийн зөвшөөрлөөр шийдвэрлэх үүрэгтэй:

3.7.1 Үйл ажиллагааны үндсэн чиглэлээс өөр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

3.7.2 Үйлдвэрийн газрын үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөрөнгө олж авах, данснаас хасах, захиалах, шинээр авах;

3.7.3 Үйлдвэрийн газрын барилга байгууламжийг зохих журмын дагуу түрээслүүлэх, түүнд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл өгөх ;

3.7.4 Салбар, төлөөлөгчийн газар байгуулах;

3.7.5 10,000,000 (арван сая) төгрөг болон түүнээс дээш хэмжээний зээл авах;

Ажил олгогчийг төлөөлж:

.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

Захирал

.....

3.7.6 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэргүүлэгчид, аймгийн Засаг даргын зөвшөөрлөөр гадаад албан томилолтоор ажиллах ба албан томилолтын удирдамж, төсвийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан томилолтын тайланг Орон нутгийн өмчийн газарт ажлын 3 өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй;

3.7.7 Үйлдвэрийн газарт осол аваар гарч онцгой нөхцөл байдал үүссэн үед зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материал худалдан авах;

3.7.8 Өөрт олгогдсон эрх хэмжээнээс хэтэрсэн аливаа асуудал;

3.8 Үйлдвэрийн газрын хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу эзэмших, ашиглах эрхтэй.

3.9 Захирал нь өмч эзэмшүүлэх гэрээг зохих журмын дагуу байгуулах, дүгнүүлэх үүрэгтэй.

3.10 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны цэвэр ашгаас орон нутгийн өмчийн ногдол ашгийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хэмжээгээр жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэгтэй.

3.11 Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, техник, бизнесийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоох, хамгаалах, тогтолцоог бий болгох үүрэгтэй.

3.12 Захирал холбогдох хууль тогтоомж, журмын дагуу ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, ахилгын шийлтгэл, хөдөлмөрийн гэрээг байгуулах, дуусгавар болгох, батлагдсан цалингийн санд багтаан ажилтнуудын цалинг тогтоох эрхтэй.

3.13 Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу анхан шатны бүртгэл хөтлөх, Эрх бүхий дээд байгууллагаас баталсан маягт, аргачлалын дагуу зохих мэдээ тайланг цаг тухайд нь гаргаж өгөх үүрэгтэй.

3.14 Захирал контрактаар хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхгүй бөгөөд бусад этгээдийн өмнө ажил, үүрэг гүйцэтгэхгүй байж контрактын биелэлтийг Аймгийн ИТХурал, Засаг даргын өмнө биечлэн хариуцах үүрэгтэй.

3.15 Үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу тогтоосон хугацаанд үйлдвэрийн газрын цахим хуудсанд тухай бүр байршуулах үүрэгтэй.

3.16 Захирал нь үйлдвэрийн газрын зорилтын санал, түүнийг хэрэгжүүлэх саналыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу гаргаж, тогтоосон хугацааны дотор Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх үүрэгтэй.

Ажил олгогчийг төлөөлж:
.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

Захирал
.....

4.5 Аймгийн ИТХурал болон Тэргүүлэгчдээс шаардлагатай гэж үзсэн нөхцөлд захиралд нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь зориулж 2 сарын үндсэн цалингаас хэтрүүлэхгүй хэмжээний мөнгөн тусламжийг тухайн үйлдвэрийн газрын санхүүгээс олгож болно.

Тав. Контрактад нэмэлт, өөрчлөлт оруулахконтрактыг дуусгавар болгох

5.1 Контрактад талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Контрактын нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэн зохих журмын дагуу баталгаажуулах бөгөөд энэхүү контрактын салшгүй хэсэг байна.

5.2 Контракт нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно:

5.2.1 Талууд харилцан тохирсон;

5.2.2 Контрактын хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон;

5.2.3 хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага шаардсан;

5.2.4 Ажлаас буруу халагдсан ажилтныг урьдах ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон;

5.2.5 Захирал цэргийн жинхэнэ албанд татагдсан;

5.2.6 Захирал гэмт хэрэг үйлдсэний улмаас ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

5.2.7 Контрактыг захирлын буюу ажил олгогчийн санаачлгаар цуцалсан;

5.3 Ажил олгогч дараах тохиолдолд контрактыг хугацаанаас нь өмнө цуцлах эрхтэй:

5.3.1 Аймгийн ИТХурал болон Тэргүүлэгчид, Засаг даргаас цуцалсан;

5.3.2 үйлдвэрийн газар татан буугдсан, дампуурсан;

5.3.3 Үйлдвэрийн газар хувьчлагдаж, өмчлөгч өөрчлөгдсөн, өмчлөх эрхээ шилжүүлсэн;

5.3.4 Захирал контрактаар хүлээсэн үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлээгүй;

5.3.5 Захирлын буруу шийдвэр, үйл ажиллагаагаар үйлдвэрийн газарт хохирол учирсан, үйлдвэрийн газар алдагдалд орсон;

5.3.6 Захирал хууль тогтоомж зөрчсөн, үйлдвэрийн газрыг удирдан зохион байгуулах үүргээ биелүүлээгүй;

Ажил олгогчийг төлөөлж:

.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

Захирал

.....

3.17 Төрийн өөрийн өмчийг бусдад түрээслүүлэхэд холбогдох хууль тогтоомж, захиргааны актыг мөрдөн ажиллах бөгөөд түрээсийн төлбөрийг тогтоосон хугацаанд аймгийн төсөвт төвлөрүүлэх үүрэгтэй.

3.18 Үйлдвэрийн газрын хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад өдөр тутас хяналт тавьж, эд хөрөнгийн дотоод тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу явуулах үүрэгтэй.

3.19 Захирал нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Авлигын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах үүрэгтэй.

3.20 Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргах эрхтэй.

3.21 Аймгийн ИТХ, Засаг дарга, эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, тогтоосон хугацаанд тайлагнах үүрэгтэй.

3.22 Эрх бүхий байгууллагаас тогтоосноос бусад өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох эрхтэй.

3.23 Маргаантай асуудлаар үйлдвэрийн газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

3.24 Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

Дөрөв. Цалин хөлс, урамшуулал, ажлын нөхцөл

4.1 Захирлын албан тушаалын сарын үндсэн цалин нь(.....)төгрөг болно.

4.2 Захиралд үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон контрактын биелэлтийг харгалзан холбогдох журмын дагуу урамшуулал олгох эсэх асуудлыг Аймгийн ИТХурал болон Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

4.3 Захирлын ээлжийн амралт болон хөдөлмөрийн харилцаатай холбогдон үүсэх энэхүү контрактаар зохицуулагдаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, дотоод журмаар зохицуулна.

4.4 Гүйцэтгэх захирлыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах ажлын байр, суудлын автомашин, үүрэн телефон, техник хэрэгслээр хангана. Суудлын автомашин үүрэн телефоны хэрэглээнд батлагдсан лимитийг баримтална.

Ажил олгогчийг төлөөлж:
.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

Захирал
.....

5.3.7 Аймгийн ИТХурал болон Тэргүүлэгчид, Засаг Даргын шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

5.3.8 Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах үүргээ биелүүлээгүйгээс компанид ноцтой осол аваар гарсны улмаас хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан, компанид их хэмжээний хохирол учирсан;

5.3.9 өөр ажил олгогчтой хөдөлмөрийн зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулсан;

5.3.10 захиралд хүлээлгэн өгсөн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, үрэгдүүлсэн өмчлөгчөөс олгосон эрх мэдлийг хэтрүүлсэн нь нотлогдсон;

5.3.11 хуульд заасан бусад үндэслэл;

5.4 Талууд контрактыг хугацаанаас нь өмнө цуцалсантай холбогдон үүсч болох тэтгэмж нөхөн олговрын асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль холбогдох бусад хууль тогтоомж дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1 Талууд контрактаар хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг бүрэн хариуцна.

6.2 Захирал нь энэхүү контракт, холбогдох журмыг зөрчсөн нөхцөлд ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулж болно.

6.3 Захирал нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ өөрийн буруугаас үйлдвэрийн газарт учруулсан эд хөрөнгийн хохирлыг эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээхээс бусад тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу зургаан сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээгээр хариуцан арилгах үүрэгтэй.

6.4 Эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр Хөдөлмөрийн тухай хуульд заасан тохиолдолд захирал нь эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ.

6.5 Захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль бусад хууль тогтоомж, компанийн дүрэм, энэ контрактад заасан хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэх урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцаж арилгана.

Долоо. Бусад

7.1 Контрактад талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, контрактын хугацаа дууссанаар дуусгавар болно.

Ажил олгогчийг төлөөлж:
.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

Захирал
.....

7.2 Энэхүү контракт нь “.....” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн хамт нийт(.....) хуудас бөгөөд монгол хэл дээр 3 хувь үйлдэж, ажил олгогч 2, захирал 1 хувийг тус тус хадгална. Контрактын эх хувь тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй байна.

7.3 Талууд контрактад тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

КОНТРАКТ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ : ЗАХИРАЛ
.....

Орон нутгийн өмчийн газрын Хаяг:
дарга Утас:
регистрын дугаар:.....
Хаяг:
утас:
факс:

Ажил олгогчийг төлөөлж:
.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

Захирал
.....

“.....” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ КОНТРАКТЫН СУНГАЛТ

20... оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Баруун-Урт
хот

Аймгийн Засаг дарга, түүнийг төлөөлж Орон нутгийн өмчийн газрын дарга
....., Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын
захиралнарын хооронд 20... оны ...дугаар сарын ...-ны
өдөр байгуулсандугаар бүхий “Контракт”-ын үйлчлэх хугацааг тухайн
нөхцөлөөр 20... оны ...дугаар ...сарын-ны өдөр хүртэл 1 жилээр сунгана.

“.....” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн
газрын 20 ...оны дугаар улирлын аудитаар баталгаажсан санхүүгийн
тайлан тэнцэлд тусгагдсан(.....) төгрөгийн үндсэн
..... төгрөгийн эргэлтийн, нийт(.....)
төгрөгийн хөрөнгийг контрактыг сунгасан өдөр хүлээлгэн өгөв.

КОНТРАКТ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

ЗАХИРАЛ

.....

.....

Орон нутгийн өмчийн газрын
дарга

Хаяг:
Утас:
регистрын дугаар:.....

Хаяг:
утас:
факс:

Ажил олгогчийг төлөөлж:

Захирал

.....
(нэр, гарын үсэг)(нэр, гарын үсэг)

.....

“.....” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ КОНТРАКТЫН ЗАГВАР

20... оныдугаар сарын
сарын-ны өдөр

Дугаар

Баруун-Урт

хот

Энэхүү контрактыг нэг талаас “.....” Орон өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, түүнийг төлөөлж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга/цаашид “ажил олгогч/ гэх, нөгөө талаас “Орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирал/цаашид “гүйцэтгэх захирал” хамтад нь талууд/ гэх, нар Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 22, 25 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү контрактын зорилго нь “.....” орон нутгийн өмчит компанийн үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, контрактаар хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, талуудын харилцан эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.

1.2 Энэхүү контракт нь 20.. оны ...дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн 20 ...оныдугаар сарын ... –ны өдрийг дуустал 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

1.3 “.....” орон нутгийн өмчиткомпанийн 20 оны дугаар улирлын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдсан(.....) төгрөгийн үндсэн(.....) төгрөгийн эргэлтийн, нийт(.....) төгрөгийн хөрөнгийг контракт байгуулсан өдөр хүлээлгэн өгөв.

1.4 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэргүүлэгчдээс баталсан “.....” орон нутгийн өмчиткомпанийн 20.. оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь энэхүү контрактын салшгүй хэсэг бөгөөд гүйцэтгэх захирлын хийх ажлын хүрэх үр дүн болно.

Ажил олгогчийг төлөөлж
.....
(нэр, гарын үсэг)

Гүйцэтгэх захирал
.....
(нэр, гарын үсэг)